ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН 2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2023 оны 08 дугаар сарын 02 Улаанбаатар хот

Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн тус байгууллагад холбогдох заалтуудын 2023 оны 07 дугаар сарын хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны А/107 дугаар тушаалаар баталсан “Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын дагуу хяналт-шинжилгээ хийж, үр дүнг үнэлэв.

Хяналт-шинжилгээ, үнэлгээнд Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлд тусгагдсан 4 арга хэмжээний 5 зүйл, заалтыг үйл ажиллагаандаа хамруулсан болно. Бүрэн хэрэгжсэн 5 зүйл, заалт байна. Үүнд:

1.Монгол Улсад 30 хүртэл хоногийн хугацаагаар жуулчлах хавсралтад дурдсан улсын иргэдийг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл Монгол Улсын визийн шаардлагаас чөлөөлсүгэй. 2.Энэ тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар нарт даалгасугай.

Хэрэгжилт: Засгийн газрын 2023 оны 01 дүгээр тогтоолоор Монгол Улсын цахим виз олгох улсын жагсаалтад багтаж байсан Европын улсууд болон Австрали, Шинэ Зеланд зэрэг 34 улсын иргэнийг визийн шаардлагаас чөлөөлснийг үндэслэн “Визийн мэдээллийн нэгдсэн сан” систем (evisa.mn)-ээс хавсралтад дурдсан улсыг хасаж, шийдвэрийг мөрдөн ажиллаж байна.

2.XXXYI.Бүгд Найрамдах Хятад Ард Улс 2023 оны 01 дүгээр сарын 08-ны өдрөөс хилийн боомтоо шат дараатайгаар нээхтэй холбогдуулан хэрэгжиж эхлэх дэглэмийн талаар Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан хилийн Гашуунсухайт боомтыг хэвийн үйл ажиллагаанд шилжих хүртэлх хугацаанд дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд бөгөөд Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны даргын үүрэг хариуцагч Х.Нямбаатар, Хилийн боомтын захиргаа (Ш.Лхачинжав) нарт даалгав: 1.хилийн Гашуунсухайт боомт дахь тээвэрлэлтийн үйл ажиллагааг зохицуулах түр журмыг баталж, мөрдүүлэх; 2.хилийн Гашуунсухайт боомтын ачаа тээвэрлэлтийн үйл ажиллагаа, орон нутаг дахь төрийн болон нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах Шуурхай штабын бүрэлдэхүүнийг томилж, үйл ажиллагааг удирдлагаар хангах.

Хэрэгжилт: Бүгд Найрамдах Хятад Ард Улсын ӨМӨЗО-ны Хөх хотод 08 дугаар сард зохион байгуулагдах Монгол, Хятадын хилийн боомтын менежментийн хамтын ажиллагааны комиссын Y дугаар нэгдсэн хуралдаанаар Сүхбаатар аймгийн хилийн Бичигт боомт, Өмнөговь аймгийн хилийн Гашуунсухайт, Шивээхүрэн боомтуудын цагийн горимд өөрчлөлт оруулах бэлтгэл ажлыг хангаж байгаатай холбогдуулан дээрх боомтуудад ажиллах хүний нөөц, албан хаагчдын цалин хөлс,

нэмэгдэл, тэтгэмж, нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор 2024 оны төсвийн төсөлд нэмэлт санал бэлтгэж, судалгаа явуулж байна.

Боомтын сэргэлтийн хүрээнд хилийн Гашуунсухайт боомтын бүтээн байгуулалтын ажил хэвийн үргэлжилж байгаа бөгөөд 07 дугаар сарын байдлаар зорчигч тээврийн хөдөлгөөн нээгдээгүй байна. Зорчигч тээврийн хөдөлгөөнийг нээхтэй холбогдуулан үйл ажиллагааны болон “ISM” системийн бэлэн байдлыг байгууллагын зүгээс хангасан болно.

3.Тогтоол батлагдсантай холбогдуулан “Монгол Улсын визийг цахимаар авах улсын жагсаалт”-д өөрчлөлт оруулах, гадаадын бусад улсыг нэмж хамруулах асуудлыг холбогдох байгууллагын саналыг харгалзан шийдвэрлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг нарт даалгав.

Хэрэгжилт: Засгийн газрын 2023 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор зарим улсын иргэнийг визийн шаардлагаас чөлөөлснийг үндэслэн “Визийн мэдээллийн нэгдсэн сан” систем (evisa.mn) дэх бүртгэлээс хавсралтад дурдсан 34 улсыг хасаж, Гадаад харилцааны сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн А/09, А/53 дугаар хамтарсан тушаалаар 98 улсыг цахим виз олгох улсын жагсаалтад нэмснийг уг системд бүрэн нэвтрүүлж, нийт 99 улсын иргэнд цахим визийг олгож байна.

- Тогтоол батлагдсантай холбогдуулан гадаадын иргэдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх, бүртгэл, хяналтыг сайжруулах чиглэлээр зохих арга хэмжээ авч ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Гадаадын иргэн, харьяатын газар (Н.Ууганбаяр), Хил хамгаалах ерөнхий газар (Х.Лхагвасүрэн), Тагнуулын ерөнхий газар (П.Одонбаатар) нарт даалгав.

Хэрэгжилт: Энэ оны өссөн дүнгээр 80 улсын 14776 иргэнд цахим виз олгосноос Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 01 дүгээр тогтоол болон Гадаад харилцааны сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны А/09, А/53 дугаар хамтарсан тушаалыг мөрдөж эхэлснээс хойш тайлант хугацаанд “Визийн мэдээллийн нэгдсэн сан” систем (evisa.mn)-ээр нийт 14240 гадаадын иргэнд цахим виз олгосон.

4.Иргэдийн зорчих нөхцөлийг хөнгөвчлөх талаар БНСУ-ын холбогдох байгууллагатай хэлэлцээ хийх үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулж, энэ хүрээнд дараах асуудлыг хэлэлцэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатарт:

- Монгол Улсын Засгийн газар болон БНСУ-ын Засгийн газар хооронд байгуулсан Нийгмийн хамгааллын тухай хэлэлцээрт холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах замаар харилцан нийгмийн даатгалаас чөлөөлөх хугацааг нэмэгдүүлэх, төлөгдсөн нийгмийн даатгалын буцаан олголтод хамаарах визийн ангилал хүрээг нэмэгдүүлэх;

- БНСУ-д эмчилгээ хийлгэж буй иргэдийг дэмжих зорилгоор тус улсын эмнэлгүүдийн төлбөрийн хөнгөлөлтийг эдлүүлэх болон эрүүл мэндийн даатгалд хамрагдах;

- Хөдөлмөрийн гэрээгээр БНСУ-д ажиллаж буй монгол иргэдийн эцэг, эх, үр хүүхэд, гэр бүлийн зүгээс тус улсад зорчих виз хүсэхэд тодорхой хөнгөлөлт эдлүүлэх.

Хэрэгжилт: Засгийн газрын 2023 оны “Монгол Улсын иргэдийн Бүгд Найрамдах Солонгос Улсад зорчих нөхцөлийг хөнгөвчлөх чиглэлээр авах арга хэмжээний тухай” 166 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах арга хэмжээний хүрээнд Гадаадын иргэн, харьяатын газраас Бүгд Найрамдах Солонгос Улсын Цагаачлалын албатай 05 дугаар сарын 19-ний өдөр хийсэн уулзалтаар хэлэлцэж тохиролцсон тодорхой хэд хэдэн асуудалд гэрээт ажилтан буюу Е-9 ангиллаар оршин сууж байгаа 4,355 иргэнийг тусгай мэргэжилтэн буюу Е-7 ангилал руу шилжүүлэх, тус улсын Засгийн газраас хууль бусаар оршин сууж буй иргэдийн тоог багасгах чиглэлээр авч хэрэгжүүлж буй бодлогын хүрээнд хууль бусаар оршин сууж буй гэр бүлийн бага насны хүүхэд сургуулийн сурагч байх тохиолдолд тэдэнд оршин суух зөвшөөрөл олгож, эцэг эхийг ажил хөдөлмөр эрхлэх бололцоогоор хангах, хууль бусаар оршин сууж буй Монгол Улсын иргэдийг нутаг буцаах аянд хамруулах, тус улсыг сайн дураар орхин гарсан иргэнд дахин хууль ёсоор зорчих баталгааг гаргах зэрэг багтсан болно.

Түүнчлэн Монгол Улсын иргэдэд хууль бусаар оршин суухын хор уршгийг таниулах, хууль бусаар оршин суусан тохиолдолд зорилтот арга хэмжээнд хамрагдан нутаг буцахад уриалах зорилгоор нэвтрүүлэг, видео танилцуулга, контент сурталчилгааны ажлуудыг тусган хэрэгжүүлэхээр тогтсоны дагуу дараах цуврал контентыг бэлтгэн Ийгл телевиз болон олон нийтийн мэдээ, мэдээллийн бусад хэрэгслээр дамжуулан нийт 6 удаа олон нийтэд хүргээд байна. Үүнд:

- Бүгд Найрамдах Солонгос Улсад хууль бусаар ажиллаж, амьдрахын хор уршгийн талаарх контентыг 06 дугаар сарын 27-ны өдөр;
- Тус улсад гэрээгээр хөдөлмөр эрхлэгч иргэд тусгай мэргэжилтэй ажилтны визийн ангилал руу шилжих боломжтойг сануулсан Бүгд Найрамдах Солонгос Улсын Соёлын салбарын мэдээллийг 06 дугаар сарын 28-ны өдөр;

Бүгд Найрамдах Солонгос Улсад гэрээгээр хөдөлмөр эрхлэгчээс тусгай мэргэжилтний оршин суух зөвшөөрлийн ангилал руу шилжсэн иргэний ярилцлагыг 06 дугаар сарын 30-ны өдөр тус бүр 2 удаагийн давтамжтай цацлаа.

Гадаадын иргэн, харьяатын газрын 2023 оны 07 дугаар сарын Монгол Улсын хууль тогтоомж, тогтоол, шийдвэрт тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилт бүрэн хэрэгжиж, 100 хувь буюу 5.0 оноотой, үр дүнтэй дүгнэгдсэн тул цаашид арга хэмжээний үр дүнг бууруулахгүйгээр чанаржуулж, үр дүнг бүрэн хангаж ажиллах шаардлагатай.

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН
ГАЗАР